

“И-Монгол академи” УТҮГ-ын Хэрэглэгчийн үйлчилгээний хэлтэст
ирүүлсэн иргэний өргөдөл, гомдол, санал, хүсэлт

2025 оны 1 дүгээр улирлын байдлаар 11-11 утасны 2 дугаар шугамаар дамжуулан (www.e-Mongolia.mn, www.e-Business.mn)-тэй холбоотой нийт **19** (санал **1**, гомдол **18**) ирүүлж хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байна. Гомдол, саналыг агуулгаар авч үзэхэд:

1. Төлбөртэй үйлчилгээ авч болохгүй байгаатай холбоотой **4** буюу 21.05%;
2. И-Монголиа систем алдаа зааснаас иргэд үйлчилгээ авч чадахгүй болсонтой холбоотой **5** буюу 26.32%;
3. И-Монголиа лавлагаагаар банк үйлчлэхгүй байгаа талаар **2** буюу 10.53%;
4. И-Монголиа системээс лавлагаа авч болохгүй байгаа талаар **1** буюу 5.26%;
5. Профайл цэсэд бичиг баримт харагдахгүй байгаа тухай **5** буюу 26.32%;
6. Нотлох баримтаар ашиглах материал авах хүсэлт гаргасан боловч хариу ирэхгүй байгаатай холбоотой **1** буюу 5.26%;
7. Иргэний бүртгэлийн дугаараар овог нэрийг шалгах боломжтой API гаргаж өгөх боломж байгаа эсэх санал **1** буюу 5.26%. Нийт И-Монголиа системтэй холбоотой **19** санал, гомдол тус тус ирснийг шийдвэрлэсэн байна.

Мэдээлэл хариуцагч байгууллагын **333** хүсэлт ирүүлсэн байна.

8. Мэдээлэл хариуцагч байгууллагын үйл ажиллагаатай холбоотой **333** хүсэлт буюу (гадаад паспорт захиалгатай холбоотой **21**, Жолооны үнэмлэх захиалгатай холбоотой **68**, Иргэний үнэмлэх захиалгатай холбоотой **61**, Шилжилт хөдөлгөөнтэй холбоотой **38**, Харилцагч байгууллагын алдаатай холбоотой **5**, Эрүүл мэндийн үйлчилгээтэй холбоотой **5**, Лавлагаа тодорхойлолттой холбоотой **3**, Иргэн жолооч авто тээврийн хэрэгслийн торгууль төлөлттэй холбоотой **98**, ДАН танилт нэвтрэлттэй холбоотой **7**, Улсын бүртгэлийн ерөнхий газрын үйлчилгээтэй холбоотой **1**, Цагдаагийн ерөнхий газрын үйлчилгээтэй холбоотой **2**, Боловсролын ерөнхий газрын үйлчилгээтэй холбоотой **7**, Төлбөртэй үйлчилгээтэй холбоотой **17**) хүсэлтийг тус тус шийдвэрлэсэн байна.